



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2026 оны 03 сарын 27 өдөр

Дугаар А/216

Булган сум

Булган зөгийн бал маркетингийн үйлчилгээг хэрэгжүүлэхэд хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, “Үйлдвэрлэлийн сэргэлт” хөтөлбөрийн 4.5 дахь хэсэг, “Шинэ хөдөө сэргэлт” хөтөлбөрийн 4.6.6 дахь заалт, аймгийн Засаг даргын 2026 оны А/97 дугаар “Хөтөлбөр, төлөвлөгөө, арга хэмжээний зардлыг батлах тухай” захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Булган аймгийн зөгийн аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдийн зах зээлд өрсөлдөх чадвар, борлуулалтын орлогыг нэмэгдүүлэх, бүтээгдэхүүний чанарыг баталгаажуулах зорилгоор “Булган зөгийн бал” маркетингийн үйлчилгээг “Хөдөөгийн шинэчлэл, хөгжлийн түншлэл” ТББ-аар гүйцэтгүүлсүгэй.

2. Маркетингийн зөвлөх үйлчилгээнд шаардагдах 10,000,000 (арван сая) төгрөгийг “Шинэ хөдөө” сэргэлт хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын тамгын газрын дарга (Д.Эрдэнэбилэг)-д зөвшөөрсүгэй.

3. Маркетингийн зөвлөх үйлчилгээг гэрээний дагуу чанартай хийлгэж, хяналт тавьж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуйн газар (Н.Пүрэвсайхан)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА Д. ПҮРЭВ-ОЧИР

